АЖЛЫН БАЙР (АЛБАН ТУШААЛ)-НЫ ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

☑ Байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тоонд өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомж, шийдвэрийн нэр, огноо:	"ИНҮТ" ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын 2025 оны А/49 дүгээр тушаал
Албан тушаалын тодорхойлолтын дугаар:	"ИНҮТ" ТӨХКК - 94
Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо, дугаар:	2025.03.14. А/124

Байгууллагын нэр:	Нэгжийн нэр:
"Иргэний нисэхийн үндэсний төв" ТӨХХК	Нисэх буудлуудын үйлчилгээний газар
Албан тушаалын нэр:	Албан тушаалын ангилал, зэрэглэл:
Аэродромын үйл ажиллагаа хариуцсан менежер	
Ажлын цаг:	Ажлын байрны албан ёсны байршил:
Ердийн	ХУД-ийн 21-р хороо, "ИНҮТ" ТӨХХК
Хөдөлмөрийн нөхцөл:	Онцгой нөхцөл:
Хэвийн	

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Төв болон орон нутгийн нисэх буудлуудыг аэродром, гэрэл суулт, гал унтраах авран хамгаалах зэрэглэлээр нь гэрчилгээжүүлэхэд үйл ажиллагааны технологийн сахилга батыг мөрдүүлж, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах.

Албан тушаалын зорилт:

1. Нисэх буудал, аэродром, гэрэл суулт, газрын үйлчилгээний үйлдвэрлэлийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, мэргэжлийн удирдлагаар хангах;
2. ИНЕГ-аас ИНД-139, ИНД-140, ИНД-144-ийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор өгсөн зөвлөмж, үл тохирлын нийцлүүдийг нэгтгэж, үйл ажиллагааны төлөвлөгөөг хянах, түүний биелэлт, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;
3. Монгол Улсын нисэх буудал, аэродромын ерөнхий төлөвлөлтийг хийх, төлөвлөлтийн тогтолцооны шинэчлэлтийг эхлүүлэх;
4. Нисэх буудлуудыг хөгжүүлэхэд чиглэсэн бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлэх;
5. Нисэх буудлын үйл ажиллагаанд оролцдог бусад дүрмийн зохицуулалттай нислэгийн хөдөлгөөний, холбоо навигацийн, нислэгийн мэдээллийн үйлчилгээ хоорондын үйлдвэрлэл технологийн үйл ажиллагааг холбож, уялдаа холбооны зохицуулалтыг хийж ажиллах;
6. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, стандартыг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх-Ш

1 дүгээр зорилтын хүрээнд	1.1 Нисэхийн болон нислэгийн аюулгүй ажиллагааны хяналтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон арга хэмжээг авч хэрэгжүүлж байх; 1.2 Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд технологийн сахилга батыг мөрдүүлэх үйлчилгээний чанарыг сайжруулах; 1.3 Үйлдвэрлэлийн хэвийн бус нөхцөл үүссэн үед холбогдох журмын дагуу шуурхай арга хэмжээг авч хэрэгжүүлж, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хэвийн горимд шилжүүлэн тогтворжуулах; 1.4 Нисэх буудал, аэродромын онцгой байдлын үед ажиллах төлөвлөгөөг олон улсын журмын дагуу байгаа эсэхэд зөвлөгөө, зөвлөмжөөр хангах;	Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа тогтмолжсон байна.	Г, Х Г, Х, Г, Х Г, Х
2 дугаар зорилтын хүрээнд	2.1 Олон улсын болон орон нутгийн аэродромуудын үйлчилгээг ИНД-139-д тавигдсан шаардлагад нийцүүлэн хангуулах ажлыг ажлыг зохион байгуулах, хяналт тавих. ажлыг зохион байгуулж, хяналт тавих; 2.2 Олон улсын болон орон нутгийн нисэх буудлуудын Аюулгүйн хамгаалалтын ерөнхий зааврыг ИНД-140 шаардлагад нийцүүлэх, хангуулах ажлыг зохион байгуулж, хяналт тавих; 2.3 Олон улсын болон орон нутгийн нисэх буудлуудын газрын үйлчилгээ, шатахуун хангамжийн үйл ажиллагааны заавар, стандартыг мөрдүүлэх, хяналт тавих, ИНД-144 шаардлагад нийцүүлэх, хангуулах ажлыг зохион байгуулж, хяналт тавих; 2.4 Нисэх буудалд нислэг үйлдвэрлэл явагдаж байгаатай холбоотойгоор ИНД-139, 140, 144 дүрмүүдийг хэрэгжүүлэхэд болзошгүй эрсдэлийг тогтоох, бууруулах, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх; 2.5 ИНЕГ болон бусад мэргэжлийн байгууллагаас ирүүлсэн дүгнэлт зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах;	Нисэх буудлуудын үйл ажиллагаа Олон улсын стандарт, шаардлага болон ИНД-ийн шаардлагыг хангасан байна.	Г, Х Г, Х Г, Х Г Г
3 дугаар зорилтын хүрээнд	3.1 Олон улсад төлөвлөгдөж баригдаж байгаа нисэх буудлын дизайн төлөвлөлтүүдийн шинэчлэлтүүдийг судлаж, Монгол улсын нисэх буудлын барилгын стандарт болгож боловсруулах хөгжүүлэх ажлыг эхлүүлэх; 3.2 Олон улсад төлөвлөгдөж баригдаж байгаа аэродромын шинэ төлөвлөлтүүдийг судлаж, “Монгол улсын аэродромын стандарт”-д хийх нэмэлт өөрчлөлтийг шинээр тусгах; 3.3 Нисэх буудал, аэродромын газрын үйлчилгээний стандарт, норм нормативуудыг шинэчлэн батлуулах ажлыг хийх; 3.4 Аэродром, нисэх буудлуудын төлөвлөлтийн ажлын хүрээнд иргэний нисэхийн чиглэлээр гадны улс оронд мэргэжил дээшлүүлэх зорилгоор сургалтад суралцах;	Холбогдох хууль, дүрэм, журмын хүрээнд байгууллагуудын ажлын уялдаа зохицуулагдсан байна.	Г Г, Х Г, Х Г
	4.1 ОУИНБ-ууд /ИКАО, ИАТА/, ИНЕГ-аас баталсан заавар, зөвлөмж, дүрэм, журмуудыг үйлдвэрлэлд нэвтрүүлж, хэрэгжүүлэх; 4.2 Төв болон орон нутгийн нисэх буудлуудын аэродром, барилга байгууламжид шаардагдах	Нисэх буудлуудыг хөгжүүлэх бодлого, зохицуулалтууд	Г Г

4 дүгээр зорилтын хүрээнд	хөрөнгө оруулалтын нэгдсэн төлөвлөгөөг нэгтгэх, үйл ажиллагаанд хяналт тавих; 4.3 Нисэх буудлуудын үйлдвэрлэл, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах чиглэлээр бодлого, төлөвлөлтийн чанартай арга хэмжээг зохион байгуулах; 4.4 Нисэх буудлуудын харилцааг шинэ түвшинд хүргэх зорилгоор олон улсын байгууллага болон төрийн бус байгууллагуудын холбоодтой мэргэжлийн байгууллагын харилцаа холбоо тогтоож хамтарч ажиллах;	хэрэгжсэн байна.	Г Г
5 дугаар зорилтын хүрээнд	5.1 Нисэх буудал болон газрын тусгай үйлчилгээ, шатахуун, аюулгүй байдал, хамгаалалтын үйлчилгээ хоорондын үйлдвэрлэл, технологийн үйл ажиллагааг холбож, уялдаа холбооны зохицуулалт хийж ажиллах 5.2 Нисэх буудлын үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааг зохион байгуулахад шаардлагатай үйл ажиллагааны заавар, хамтын ажиллагааны журам, зааврыг боловсруулан гаргаж, хяналт зохицуулалт шинэчлэлтийг хийж гүйцэтгэх; 5.3 Нисэх буудал болон нислэгийн хөдөлгөөний, холбоо навигацийн, нислэгийн мэдээллийн үйлчилгээ хоорондын үйлдвэрлэл технологийн үйл ажиллагааг хооронд нь холбож, уялдаа холбооны зохицуулалтыг хийж ажиллах;	Нисэх буудлын үйл ажиллагаанд оролцдог агаарын навигацийн үйлчилгээний нэгжүүдийн уялдаа холбоо сайжирсан байна.	Г Г, Х Г, Х
5 дугаар зорилтын хүрээнд	5.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, стандартыг хэрэгжүүлэх, өөрийн харьяалах ажлын байр болон үйлдвэрлэлийн орчинд тохирсон дүрэм, журмыг боловсруулахад оролцох; 5.2 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, зохион байгуулах, хяналт тавих, үр дүнг тооцох, удирдлагын тогтолцоог нэвтрүүлэхэд ажилтнаа манлайлан ажиллах; 5.3 Осолд дөхсөн тохиолдлыг бүртгэх болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, үйлдвэрлэлийн орчинд учирч болох аюулыг илрүүлэх, тогтоох, үнэлэх, бууруулах, арилгах талаар хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтанд мэдээлэх, хамтран ажиллах; 5.4 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27.3,28 дугаар зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд ажил олгогч болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтантай хамтран ажиллах;	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийг хэрэгжүүлсэн байна.	Г, Т Г, Х, Т Г, Т Г, Т
Ажлын байрны зорилгын хүрээнд явуулах бусад үйл ажиллагаа	• Удирдлагын өгсөн чиглэлээр санал боловсруулах, удирдлагыг шаардлагатай мэдээллээр хангах, ажлын явцыг удирдлагад танилцуулах; • Үйл ажиллагаатай холбогдол бүхий санал, зөрчлийн мэдээллийг удирдлагад мэдэгдэх, зөрчлийг арилгах арга хэмжээг зохион байгуулах; • Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, төрийн захиргааны төв байгууллагын болон компанийн гүйцэтгэх захирлын тушаал,	Удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгавар, ажлын байрны хүрээнд явагдсан бусад үйл ажиллагаа бүрэн хангагдсан байна.	Г Г Г

	шийдвэр, цаг үеийн болон бусад асуудлаар удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх; • Газрын хэмжээнд хэрэгжих ажлын төлөвлөгөө, тайлангуудын хэрэгжилт, гүйцэтгэлийн үнэн зөв байдалд хяналт тавих; • Архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомж, баримт бичгийн стандартыг нэгжийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих; • Шууд харьяалах албан тушаалтнуудын ажлын гүйцэтгэлд үнэлэлт өгч, санал танилцуулах;		Г Г Г

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА		
Боловсрол	Дээд боловсролтой, бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй	
Мэргэжил	Аэродромын инженер, нисэх буудлын үйлдвэрлэлийн инженер	
Мэргэшил	Аэродром, иргэний нисэхийн болон нисэх буудлын менежментийн сургалтад хамрагдсан байх.	
Туршлага	Аэродром, нисэх буудал, нисэх буудлын мэргэжлийн хэлтэст 10-аас доошгүй жил ажилласан, үүнээс аэродром, нисэх буудлын чиглэлээр 5-аас доошгүй жил удирдах албан тушаалд ажилласан байх.	
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	• Хариуцсан нэгжийн үйл ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэлийг дүгнэж, шаардлага тавьж чаддаг байх; • Удирдлагадаа байгаа ажилтнуудын ажил үүргийг оновчтой хуваарилах, удирдах; • Ажилтнуудын ажлын гүйцэтгэлд өдөр тутам хяналт тавьж, зохих заавар чиглэл өгөх; • Удирдлага зохион байгуулалтыг хэрэгжүүлэхдээ ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдөх; • Ажилтнуудын хувь хүний хөгжлийг дэмжиж, бүтээлч шинэ санаа гаргах, идэвх санаачлагатай ажиллах боломжоор хангах.
	Дүн шинжилгээ хийх	• Албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээллийг цуглуулж, дүгнэх; • Гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; • Судалгааны ерөнхий арга зүйн мэдлэгтэй байх; • Шийдвэрийн шууд болон шууд бус үр дагаварыг үнэлж, шийдлийн хувилбарын талаар зөвлөх.
	Асуудал шийдвэрлэх	• Хуульд нийцсэн, оновчтой, үр дүнтэй шийдвэрийг шуурхай гаргах; • Өөрийн чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах; • Албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд аливаа асуудлыг хууль болон ёс зүйг сахиж, ашиг сонирхлоос аливаа зөрчлөөс сэргийлж, авлига, хүнд суртлаас ангид ажиллах; • Тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, хувилбарыг боловсруулж, түүний эерэг, сөрөг үр дагаврын талаар удирдлагад танилцуулах.
	Манлайлах	• Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах; • Бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох; • Ажил хэргийн хувьд бүтээлч, санаачилгатай ажиллах;
	Бусад	• Албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах; • Монгол хэл, бичгийн дүрмийн дагуу үг үсгийн болон утга найруулгын алдаагүй бичих; • Монгол бичгийн дунд шатны мэдлэгтэй байх; • Компьютерын өргөн хэрэглээний программуудыг ашиглаж чаддаг байх; • Хувийн зохион байгуулалт, цаг ашиглалтын менежмент сайтай байх;

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:
Нисэх буудлуудын үйлчилгээний газрын дарга

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:	Бусад харилцах субъект:
- Ахлах технологч мэргэжилтэн – 5 - Технологч мэргэжилтэн -5 - Мэргэжилтэн -1	- ИНЕГ, Компанийн харьяа салбар, нэгжүүд - Иргэний нисэхийн салбарын бусад байгууллагууд - Агаарын тээвэрлэгч байгуулагууд - Орон нутгийн нисэх буудлууд - Ажил хэргийн хүрээнд харилцах бусад байгууллага, иргэд

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
Албан тушаал: ЗАХИРГАА, САНХҮҮ ХАРИУЦСАН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР Н.ЗОЛЖАРГАЛ 2025 оны 03 дугаар сарын 14-ны өдөр	Байгууллагын нэр: "ИНҮТ" ТӨХХК Шийдвэрийн огноо: 2025.02.18 Дугаар: А/49

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр: "ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ" ТӨХХК

Шийдвэрийн огноо: 2025 оны 03 дугаар сарын 14 өдөр

Дугаар: А/124

(тамга/тэмдэг)

"ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ" ТӨХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.ОТГОНСҮХ

2025 оны 03 дугаар сарын 14-ны өдөр